

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО.

УИХ-аас 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр томилогдсон Монголбанкны Хяналтын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн анхны хурлаа 2010 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа.

Уг хурлаар Монголбанкны 2009 оны захиргаа, аж ахуйн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг шалгасан тухай Хяналтын зөвлөлийн гишүүн Д.Моломжамц, Монголбанкны Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэр, түүний биелэлтийн байдлыг шалгасан тухай Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Энхбаатар, Монголбанкны гадаад активын байршил, түүний эрсдэлийн байдлыг шалгасан талаар Хяналтын зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбат нарын мэдээллийг тус тус авч хэлэлцээд Хяналтын зөвлөлийн хурлаас дараах зөвлөмжийг Монголбанкны удирдлагад хүргүүлэхээр тогтсон байна. Үүнд:

1. Монголбанкны системийн төсөв зохиох аргачлалыг боловсронгуй болгох, орлого, зарлагыг нэр төрлөөр нь сарын хуваарьтайгаар газар, хэлтэс, Монголбанкны орон нутаг дахь салбар тус бүрээр төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах журамд шилжих;

2. Монголбанкны системийн захиргааны төсвийн орлогоос давсан зардал буюу алдагдлыг нөхөхөд зориулж Монголбанкны үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулах хөрөнгийн хэмжээг УИХ-аас жил бүр тогтоолгож авч, энэ үндсэн дээр Монголбанкны системийн төсөв буюу орлого зарлагын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3. Голомт, Хадгаламж банкууд болон бусад түрээслэгч нартай байгуулсан байр талбай түрээслэх тухай гэрээний нөхцлийг жил бүр хянан үзэж, үнэ тарифын өөрчлөлттэй нийцүүлэхийн хамт, түрээсийг 5 хүртэл жилээр хийх журамд шилжих;

4. Төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны эрх үүргийг зохицуулсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай 2002 оноос мөрдөж байгаа хуулийг Монголбанк үйл ажиллагаандаа мөрдөх, эсэх асуудлыг УИХ-д тавьж шийдвэрлүүлэх;

5. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын тайланг харилцагчийн нууц түүнчлэн Төв банкны үйл ажиллагаа, түүний олон улсын туршлагад үндэслэсэн нууцалж болох мэдээллээс бусад мэдээллийг нийгэд ил тод болгох;

Мөн Хяналтын зөвлөлийн хурлаас гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагыг барагдуулах талаар урьд жилүүдэд Хяналтын зөвлөлөөс Монголбанкны удирдлагад хүргүүлж байсан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй байгааг тэмдэглэж, Монголбанкны тайлан бүртгэлд бүртгэлтэй байгаа авлагыг барагдуулах талаар хийж байгаа ажлын явц, үр дүнгийн талаар Монголбанкны Тамгын газрын захирал Г.Цэрэнпүрэвийн мэдээллийг 2010 оны 9 дүгээр сард тусгайлан сонсохоор шийдвэрлэсэн болно.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ